

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэндхүү	Дугаар	L337
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Эрдэнэдалай
Төрсөн газар	Эрдэнэдалай сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дэлгэрэхийн хурал	Сүм хийдийн дугаар	ДУЭД 003
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 27	Ярилцлага авсан хүн	Жужа

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Дэлгэрэхийн хурал

Жужа: Таниас энэ Дэлгэрэхийн хурлын талаар ярилцлага авах санаатай. Тэнд бага байхдаа очдог байсан үү?

Цэндхүү: Манай энд байшин ч байсан, байшин барилга дуган байсан шүү дээ.

Жужа: Хэдэн дуган байсан?

Цэндхүү: Аа нэг л сайхан дуган байсан. Тэгээд байшин барилга зөндөө байсан, энэ дээр чинь байшинтай айл зөндөө байсан. Их олон айл байдаг байсан юм.

Жужа: Тэр дуган юугаар хийсэн дуган байсан бэ?

Цэндхүү: Аа нэг л сайхан их олон лам нартай том дуган байсан. Сайн мэдэхгүй байна, мартчихаж. Намайг бага байхад л сайхан дуган. Их л олон сайн лам нартай байсан. Дээр үед лам нар баригдаад явсан ш дээ. Тэгэхэд л баригдаад явчихсан.

Жужа: Хэдэн лам байсан бэ?

Цэндхүү: Одоо санахад арав гаран лам байсан. Одоо байсан бол зарим нь байж ч мэдэхээр, ихэнх нь байхгүй байх тийм насны лам нар байсан.

Энхбаяр: Хамба лам, ловон ч юм үү хамгийн том ламыг нь мэдэх үү?

Цэндхүү: Мэдэхгүй ээ.

Жужа: Суварга байсан үү?

Цэндхүү: Суварга байсныг нь сайн мэдэхгүй. Сайхан дуган байсныг нь л санаж байна. Харин одоо энд байгаа Шатар гэдэг лам мэдэж магадгүй. Би их бага байсан. Үүнийг бараг устаж байх үед нь манайх нүүж ирсэн. Манайх уг нь энэ хойд Өвөрхангайн Баян-Өндрийн айл шүү дээ. Манай гэрийн хүн уг нь Цогтын хүн байсан юм. Би өөрөө Өвөрхангайн Баян-Өндрийнх.

Энхбаяр: Одоо энэ хийдийн түүрин дээгүүр юу байна?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэндхүү: Юу ч байхгүй. Шавар бурхан энэ тэр аятайхан юм байсныг нь амьтан түүгээд авчихсан юм гэнэ лээ. Одоо газарт ил л юм байхгүй. Далд юу байдаг юм мэдэхгүй.

Энхбаяр: Цам харайх, майдар эргэх гэдэг ч юм үү тийм юм болж байв үү?

Цэндхүү: Байсан байх, байсан байх. Би сайн санахгүй. Их л сайхан лам нар байсан юм даг. Тэгээд бүгд баригдаад явсан.

Жужа: Хэдэн онд хаагдаж нураагдсан бэ гэдгийг та мэдэх үү?

Цэндхүү: Жинхэнэ хаагдсаныг нь би мэдэхгүй. Нураагаад хоёр гурван жил болсны дараа манайх ирсэн. Лав л нураагаад л аваад явсан юм даг. Эзгүй дуганыг лам нарыг аваад явчихсан. Дуган эзгүйрсэн байсан.

Энхбаяр: Хэдэн онд танайх нүүж ирсэн юм бэ?

Цэндхүү: Би мартчихаж, хэдэн оныг санахгүй байна. Би нэг хорин хэдтэй л байсан болов уу. Одоо ная гарж байгаа хүн чинь, нэлээн хэдэн жил болж. Тэр бүгдийг санахгүй байна.

Жужа: Та яг хэдэн настай вэ?

Цэндхүү: Би могойтой хүн. Одоо далан естэй, хуучнаар 80-ны даваан дээр байна.

Жужа: Таны эцэг хаана лам байсан бэ?

Цэндхүү: Миний эцэг энд ч лам байсан, Улаанбаатарт ч лам байсан. Сайхан лам хүн байсан. Одоо их дээр үеийн хүн ш дээ. Одоо байвал байхгүй байх тийм өндөр настай хүн байсан. Би хамгийн бага охин нь гээд бодохоор, их дээр үеийн хүн хөөрхий. Есөн хүүхдийн хамгийн отгон нь, миний эх ерэн гурав хүрч өнгөрсөн. Тийм хүн байсан.